



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН КОНСЕРВАТОРИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/45/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Аудитор: Д.Зэндмэнэ
Утас: 261628 Цахим хаяг: zendmened@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Аккурэйт финанс Аудит ХХК
Захирал: Ж.Оюунбилэг
Цахим хаяг: acc.fin.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Материаллаг байдал	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт	21
4.1 Залруулсан алдаа	21
4.3 Албан шаардлага	21
4.4 Зөвлөмж.....	22
5. 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
ЗГ	Засгийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН КОНСЕРВАТОРИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.ПҮРЭВХҮҮ ТАНАА

2022.02.24 № 07/334
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын консерваторийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Монгол Улсын консерваторийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 86,825.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшинээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн "Тохиолдсон байх", "Үнэн зөв байдал", "Толилуулга ба тодруулга", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

\\10.10.10.20\Bichig_KhereglYawsan_Bichig\2022\0225 Auditin 2 Gazar -1.Docx

001050302

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,606,100.00	4,986,740.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	17,600.00	-
31110	Төгрөг	17,600.00	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,588,500.00	4,986,740.00
31210	Төгрөг	2,588,500.00	4,986,740.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	2,588,500.00	4,986,740.00
31220	Гадаад валют	-	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
32100	Үнэт цаас	-	-
33	АВЛАГА	904,080.00	222,000.00
33500	Бусад авлага	904,080.00	222,000.00
3351	Байгууллагаас авах авлага	904,080.00	222,000.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	-	-
33620	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	-
34710	Урьдчилгаа тооцоо	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	222,065,402.90	172,392,047.07
35100	Түүхий эд материал	17,032,538.00	17,009,411.00
35110	Тусгай зориулалттай материал	16,285,394.00	16,285,394.00
35130	Эм боох материал	747,144.00	747,017.00
35400	Хангамжийн материал	205,032,864.90	155,382,636.07
35410	Бичиг хэргийн материал	4,906,795.00	4,784,690.00
35420	Аж ахуйн материал	149,739,030.90	95,060,606.07
35430	Сэлбэг хэрэгсэл	43,000.00	43,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,660,000.00	250,000.00
35450	Барилгын засварын материал	10,012,850.00	1,182,900.00
35470	Бусад хангамжийн материал	38,671,189.00	54,061,440.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	225,575,582.90	177,600,787.07
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
37100	Урт хугацаат хадгаламж	-	-
37200	Үнэт цаас	-	-
37300	Урт хугацаат зээл	-	-
37310	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	-	-
37320	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	-	-

39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,868,330,821.18	10,732,815,134.77
39200	Биет хөрөнгө	10,034,538,060.30	9,898,607,984.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,503,526,410.85	9,503,526,410.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(529,141,665.51)	(805,215,577.95)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	47,400,000.00	47,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,504,999.64)	(19,108,333.41)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,139,506,690.35	2,454,986,650.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,380,649,729.39)	(1,526,849,560.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	675,622,695.90	703,550,695.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(545,197,776.17)	(603,165,034.34)
39214	Бусад үндсэн хөрөнгө	27,867,942.40	27,867,942.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(21,977,525.81)	(22,549,525.85)
39217	Ном	133,086,017.32	137,164,317.32
39300	Биет бус хөрөнгө	833,792,760.88	834,207,149.78
39301	Програм хангамж	16,064,000.00	18,064,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,313,639.12)	(8,899,250.22)
39303	Бусад биет бус хөрөнгө	825,042,400.00	825,042,400.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,868,330,821.18</u>	<u>10,732,815,134.77</u>
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>11,093,906,404.08</u>	<u>10,910,415,921.84</u>
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
41440	Бусад урьдчилж орсон орлого	-	-
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>11,093,906,404.08</u>	<u>10,910,415,921.84</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	8,010,432,655.62	8,010,432,655.62
51100	Засгийн газрын оруулсан капитал	8,010,432,655.62	8,010,432,655.62
51200	Хуримтлагдсан үр дүн	(2,042,089,139.45)	(2,225,579,621.69)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,710,162,657.37)	(2,042,089,139.45)
51220	Тайлант үеийн үр дүн	(331,926,482.08)	(183,490,482.24)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,125,562,887.91	5,125,562,887.91
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>11,093,906,404.08</u>	<u>10,910,415,921.84</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	4,722,774,375.00	5,061,974,124.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,722,774,375.00	5,061,974,124.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	336,055,475.00	834,160,872.00
120	Нийтлэг татварын бус орлого	296,332,999.00	543,574,712.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	296,332,999.00	543,574,712.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	228,357,420.00	502,129,761.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,792,090.00	22,741,100.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	1,541,451.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Материал	42,183,489.00	42,183,489.00
122	Тусламжийн орлого	39,722,476.00	290,586,160.00
122001	Хандив тусламж /дотоод	39,722,476.00	290,586,160.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,386,718,900.00	4,227,813,252.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,380,500,400.00	4,097,434,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,380,500,400.00	4,097,434,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,218,500.00	130,379,052.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00	115,199,000.00
131104	Нэмэлт санхүүжилт	260,000.00	745,473.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	958,500.00	14,434,579.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,054,700,857.08	5,245,464,606.24
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,054,700,857.08	5,245,464,606.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,054,700,857.08	5,245,464,606.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,257,802,363.12	4,890,237,210.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,242,454,375.20	3,463,230,799.42
210101	Үндсэн цалин	1,717,996,067.41	2,087,612,632.08
210102	Нэмэгдэл	1,420,935,822.66	1,255,334,429.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,550,400.00	92,260,000.00
210104	Урамшуулал	48,972,085.13	28,023,737.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	190,889,237.68	400,645,621.69
210201	Тэтгэврийн даатгал	70,092,974.85	304,747,884.64
210202	Тэтгэмжийн даатгал	56,844,977.20	45,186,651.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,125,173.68	14,056,304.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,279,200.65	2,813,756.70
210205	Эрүүл мэндийн даатгал	54,546,911.30	33,841,023.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,152,885.31	190,594,702.93
210301	Гэрэл, цахилгаан	41,273,318.00	40,387,364.08
210302	Түлш, халаалт	67,907,356.31	69,325,771.85
210303	Цэвэр, бохир ус	13,972,211.00	20,881,567.00
210304	Байрны түрээс	15,000,000.00	60,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,265,586.00	107,623,112.83
210401	Бичиг хэрэг	8,336,960.00	9,298,895.00
210402	Тээвэр, шатахуун	2,908,128.00	2,032,257.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,028,797.00	10,543,393.00
210404	Ном, хэвлэл	384,100.00	2,135,180.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,776,000.00	8,290,473.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	838,900.00	4,031,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	18,992,701.00	71,291,614.83
2105	Нормативт зардал	37,895,622.00	38,416,927.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	195,447.00	1,548,897.00
210502	Хоол, хүнс	37,071,175.00	36,131,030.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	629,000.00	737,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,543,350.00	14,320,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	299,900.00	-
210604	Урсгал засвар	11,243,450.00	14,320,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114,035,780.00	129,930,596.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,520,680.00	82,721,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,000,000.00	18,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,100.00	317,596.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,372,000.00	28,392,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	470,565,526.93	545,474,650.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,181,450.00	3,366,829.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,307,410.00	57,105,875.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	456,076,666.93	485,001,946.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	796,898,493.96	355,227,395.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	230,817,900.00	151,749,684.95
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,530,200.00	14,496,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	198,012,260.00	103,281,949.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,275,440.00	33,971,235.95
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	566,022,093.96	202,826,767.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	566,022,093.96	202,826,767.96
	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	58,500.00	650,943.05
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	58,500.00	650,943.05
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(331,926,482.08)	(183,490,482.24)
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(331,926,482.08)	(183,490,482.24)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,640,868,410.00	4,752,684,113.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	254,149,510.00	524,870,861.00
120	Нийтлэг татварын бус орлого	254,149,510.00	524,870,861.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	254,149,510.00	524,870,861.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	228,357,420.00	502,129,761.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,792,090.00	22,741,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,386,718,900.00	4,227,813,252.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,380,500,400.00	4,097,434,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,380,500,400.00	4,097,434,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,218,500.00	130,379,052.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00	115,199,000.32
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	900,000.00	-
131104	Нэмэгдэл санхүүжилт	260,000.00	745,473.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	58,500.00	14,434,579.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,611,980,010.00	4,708,565,773.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,611,980,010.00	4,708,565,773.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,815,081,516.04	4,353,338,377.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,267,313,132.39	3,461,597,035.36
210101	Үндсэн цалин	2,267,363,752.80	2,478,195,771.60
210102	Нэмэгдэл	924,733,594.48	863,669,469.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	56,425,307.40	91,708,056.65
210104	Урамшуулал	18,790,477.71	28,023,737.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	167,182,733.34	401,487,805.75
210201	Тэтгэврийн даатгал	137,145,894.63	283,135,762.88
210202	Тэтгэмжийн даатгал	168,000.00	44,250,300.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	30,240.00	14,056,304.98
210204	Ажилгүйдлийн даатгал	7,560.00	2,813,756.70
210205	Эрүүл мэндийн даатгал	29,831,038.71	57,231,680.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,152,885.31	190,594,702.93
210301	Гэрэл, цахилгаан	41,273,318.00	37,457,553.18
210302	Түлш, халаалт	67,907,356.31	72,255,582.75
210303	Цэвэр, бохир ус	13,972,211.00	20,881,567.00
210304	Байрны түрээс	15,000,000.00	60,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,978,850.00	40,536,076.00
210401	Бичиг хэрэг	4,565,555.00	4,663,990.00
210402	Тээвэр, шатахуун	4,046,048.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,692,897.00	10,543,393.00
210404	Ном, хэвлэл	517,150.00	2,135,180.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,776,000.00	8,290,473.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,381,200.00	14,703,040.00
2105	Нормативт зардал	39,822,275.00	38,719,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,122,100.00	1,905,670.00
210502	Хоол, хүнс	37,071,175.00	36,131,030.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	629,000.00	682,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,628,700.00	16,382,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,303,700.00	1,524,300.00
210602	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	825,000.00	-
210604	Урсгал засвар	20,500,000.00	14,858,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114,035,780.00	140,835,453.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,520,680.00	93,125,857.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,000,000.00	18,500,000.00
210803	Тээврийн хэрэгслийн татвар	143,100.00	317,596.00
210804	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,372,000.00	28,892,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,967,160.00	63,185,104.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,833,450.00	4,734,629.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,133,710.00	58,450,475.00
II	ХӨРӨНГИЙН ОРЛОГО	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	796,898,493.96	355,227,395.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	230,817,900.00	151,749,684.95
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,380,200.00	14,496,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	214,667,700.00	103,281,949.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,770,000.00	33,971,235.95
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	566,022,093.96	202,826,767.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	566,022,093.96	202,826,767.96
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	58,500.00	650,943.05
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	58,500.00	650,943.05
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	28,888,400.00	44,118,340.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	28,870,800.00	41,737,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,870,800.00	41,737,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,870,800.00	41,737,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,870,800.00	41,737,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(28,870,800.00)	(41,737,700.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	17,600.00	2,380,640.00
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,588,500.00	2,606,100.00
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,606,100.00	4,986,740.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,010,432,655.62	5,125,562,887.91	(1,710,162,657.37)	11,425,832,886.16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлэх үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(331,926,482.08)	(331,926,482.08)
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,010,432,655.62	5,125,562,887.91	(2,042,089,139.45)	11,093,906,404.08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлэх үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(183,490,482.24)	(183,490,482.24)
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,010,432,655.62	5,125,562,887.91	(2,225,579,621.69)	10,910,415,921.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,506,406,200.00	4,417,097,653.04	89,308,546.96	98.02
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,506,406,200.00	4,417,097,653.04	89,308,546.96	98.02
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	4,364,385,300.00	4,296,769,204.04	67,616,095.96	98.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	483,806,700.00	433,684,362.93	50,122,337.07	89.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,463,320,400.00	3,461,597,035.36	1,723,364.64	99.95
210101	Үндсэн цалин	2,448,089,100.00	2,478,195,771.60	(30,106,671.60)	101.23
210102	Нэмэгдэл цалин	865,041,300.00	863,669,469.26	1,371,830.74	99.84
210103	Унаа хоолны нэмэгдэл	80,190,000.00	91,708,056.65	(11,518,056.65)	114.36
210104	Урамшуулал	70,000,000.00	28,023,737.85	41,976,262.15	40.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	417,258,200.00	401,487,805.75	15,770,394.25	96.22
210201	Тэтгэврийн даатгал	261,266,200.00	283,135,762.88	(21,869,562.88)	108.37
210202	Тэтгэмжийн даатгал	38,998,000.00	44,250,300.00	5,252,300.29	113.47
210203	ҮОМШӨ ний даатгал	31,198,400.00	14,056,304.98	17,142,095.02	45.05
210204	Ажилгүйдлийн даатгал	7,799,600.00	2,813,756.70	4,985,843.30	36.08
210205	Эрүүл мэндийн даатгал	77,996,000.00	57,231,680.90	20,764,319.10	73.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	209,874,100.00	190,594,702.93	19,279,397.07	90.81
210301	Гэрэл цахилгаан	43,008,400.00	37,457,553.18	5,550,846.82	87.09
210302	Түлш, халаалт	72,532,700.00	72,255,582.75	277,117.25	99.62
210303	Цэвэр, бохир ус	17,680,000.00	20,881,567.00	(3,201,567.00)	118.11
210304	Байрны түрээс	76,653,000.00	60,000,000.00	16,653,000.00	78.27
2104	Хангамж, бараа материалын зардал	38,399,700.00	35,974,003.00	2,425,697.00	93.68
210401	Бичиг хэрэг	3,883,200.00	4,663,990.00	(780,790.00)	120.11
210402	Тээвэр, шатахуун	3,818,800.00	-	3,818,800.00	-
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	9,718,200.00	9,193,393.00	524,807.00	94.60
210404	Ном, хэвлэл	2,296,500.00	2,065,180.00	231,320.00	89.93
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,920,800.00	7,920,000.00	800.00	99.99
210406	<u>БҮТЭЗҮЙЛС</u>	10,762,200.00	12,131,440.00	(1,369,240.00)	112.72
2105	Нормативт зардал	64,837,800.00	38,719,600.00	26,118,200.00	59.72
210501	<u>Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл</u>	1,910,800.00	1,905,670.00	5,130.00	99.73
210502	<u>Хоол хүнс</u>	62,244,100.00	36,131,030.00	26,113,070.00	58.05
210503	<u>Нормын хувцас, зөөлөн эдлэл</u>	682,900.00	682,900.00	-	100.00
2106	<u>Эд хогшил, урсгал засварын зардал</u>	22,144,700.00	21,846,900.00	297,800.00	98.66

Монгол Улсын консерваторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	<u>Багаж, техник хэрэгсэл</u>	5,744,700.00	5,449,700.00	295,000.00	94.86
210604	<u>Урсгал засвар</u>	16,400,000.00	16,397,200.00	2,800.00	99.98
2107	<u>Томилолт, зочны зардал</u>	984,000.00	-	984,000.00	-
210702	<u>Дотоод албан томилолт</u>	984,000.00	-	984,000.00	-
2108	<u>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</u>	115,230,400.00	114,774,582.00	455,818.00	99.60
210801	<u>Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж</u>	87,859,400.00	87,704,986.00	154,414.00	99.82
210802	<u>Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал</u>	18,500,000.00	18,500,000.00	-	100.00
210803	<u>Тээврийн хэрэгслийн татвар</u>	319,000.00	317,596.00	1,404.00	99.56
210804	<u>Мэдээлэл, технологийн үйлчилгээ</u>	8,552,000.00	8,252,000.00	300,000.00	96.49
2109	<u>Бараа үйлчилгээний бусад зардал</u>	32,336,000.00	31,771,575.00	561,425.00	98.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,680,800.00	3,249,500.00	431,300.00	88.28
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,655,200.00	28,525,075.00	130,125.00	99.55
213	<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</u>	142,020,900.00	120,328,449.00	21,692,451.00	84.73
2132	<u>Бусад урсгал шилжүүлэг</u>	142,020,900.00	120,328,449.00	21,692,451.00	84.73
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,587,100.00	14,496,500.00	21,090,600.00	40.74
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	103,833,800.00	103,281,949.00	551,851.00	99.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,600,000.00	2,550,000.00	50,000.00	98.08
1	<u>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</u>	4,506,406,200.00	4,417,080,053.04	89,326,146.96	98.02
1200041	<u>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</u>	386,472,000.00	499,731,521.00	(113,259,521.00)	129.31
1200041_1	Үндсэн үйл ажиллагааны орлого	386,472,000.00	499,731,521.00	(113,259,521.00)	129.31
1200042	<u>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</u>	22,500,000.00	22,741,100.00	(241,100.00)	101.07
1200042_1	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	22,500,000.00	22,741,100.00	(241,100.00)	101.07
13	<u>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u>	4,097,434,200.00	3,894,607,432.04	202,826,767.96	95.05
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,097,434,200.00	3,894,607,432.04	202,826,767.96	95.05
	ТОХИРУУЛГЫН ДҮН	-	-	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		17,600.00	(17,600.00)	-
3101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
900	Ажиллагсдын тоо	245	245	-	100.00
9001	Удирдах ажилтан	3	12	(9)	400.00
9002	Гүйцэтгэх ажилтан	206	197	9	95.63
9003	Үйлчлэх ажилтан	36	36	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/
/Төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	<u>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</u>	-	130,379,052.00
II	<u>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</u>	-	130,379,052.00
21	<u>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</u>	-	130,379,052.00
210	<u>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</u>	-	98,306,873.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,092,073.00
210402	Тээвэр шатахуун	-	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,350,000.00
210404	Ном, хэвлэл	-	1,600,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн урсгал	-	370,473.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,571,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	16,285,000.00
210601	Багаж техник хэрэгсэл	-	16,285,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	28,960,871.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	-	8,320,871.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	20,640,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	46,968,929.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,485,129.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	45,483,800.00
213	<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</u>	-	32,072,179.00
3132	<u>Бусад урсгал шилжүүлэг</u>	-	31,421,235.95
39209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	31,421,235.95
2133	Олгосон санхүүжилт шилжүүлэг шилжүүлэг	-	650,943.05
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт	-	650,943.05
13	<u>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</u>	-	130,379,052.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	130,379,052.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	115,199,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	745,473.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	14,434,579.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол Улсын консерваторийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 15-ны хооронд Аккурэйт финанс Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Бат-Эрдэнэ, аудитор Л.Баярмаа, аудитор Я.Золзаяа, аудиторын туслах А.Алтанчимэг нар гүйцэтгэж чанарын хяналтыг захирал Ж.Оюунбилэг, чанарын хяналтын менежер Л.Гоёцэцэг нар хэрэгжүүлсэн.

Монгол Улсын консерваторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол Улсын Консерватори нь Монгол Улсын мэргэжлийн урлагийн байгууллага бөгөөд сургалтын нийтлэг шаардлага, нийгмийн эрэлтэд нийцсэн бүрэн дунд, мэргэжлийн, бакалавр, магистр, докторын боловсролтой чадварлаг мэргэжилтэн бэлтгэх үндсэн чиг үүрэгтэй.

Монгол Улсын Консерваторийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь тогтвортой хөгжих нөхцөлийг хангасан Зүүн хойд Азийн тэргүүлэх Консерваториудын нэг болоход оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2-д боловсролын салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохтой холбоотой санал боловсруулах, салбарынхаа холбогдох төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон шаардлагатай дүрэм, журам, заавар, аргачлал, боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үр дүнг тооцох;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Монгол Улсын Консерватори нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, өөрийн онцлог үйл ажиллагаанд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, бусад холбогдох журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас Ковид-19 цар тахлын улмаас 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээний ажилтны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шинжилгээ үнэлгээний ажилтны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын консерваторийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн, байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,245,464.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 52,454.6 мянган төгрөгөөр тогтоосон

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Монгол Улсын консерваторийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 183,490.5 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурч, материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,606.1	4,986.7	2,380.6
Авлага	904.0	222.0	(682.0)
Бараа материал	222,065.4	172,392.0	(49,673.4)
Үндсэн хөрөнгө	10,868,330.8	10,732,815.1	(135,515.7)
Нийт хөрөнгө	11,093,906.4	10,910,415.9	(183,490.5)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	11,093,906.4	10,910,415.9	(183,490.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,093,906.4	10,910,415.9	(183,490.5)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,380.6 мянган төгрөгөөр өссөн нь төлөвлөснөөс санхүүжилт илүү авсан;
- Авлагын данс 682.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд харилцагч байгууллагаас авах авлагаа барагдуулсан;
- Бараа материалын дансны үлдэгдэл 49,673.4 мянган төгрөгөөр буурсан нь 64,578.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 74,747.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, хандиваар хичээл практикийн материал 1,541.5 мянган төгрөг нэмэгдэж, 41,045.2 мянган төгрөгийн бичиг хэрэг, ахуйн материал акталснаас шалтгаалсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 135,515.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 41,737.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ном, бусад хөрөнгө худалдан авсан, хандиваар 38,661.5 мянган төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмж, тавилга нэмэгдсэн, Нийслэлийн боловсролын газраас 17,162.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, БШУЯ-наас үнэ төлбөргүйгээр 245,421.6 мянган төгрөгийн үлээвэр хөгжим, 6,503.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн хүлээн авч нийт 349,486.4 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, 485,001.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцоолон бүртгэсэн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Монгол Улсын консерваторийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,720,906.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,720,906.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 214,500.0 мянган төгрөгөөр бууруулж 4,506,406.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс цалин, нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 227,500.0 мянган төгрөгөөр бууруулж, хангамж бараа материалын зардлыг 4,300.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн, ажил үйлчилгээний зардлыг 8,700.0 мянган төгрөгөөр өсгөн нийт 214,500.0 мянган төгрөгөөр бууруулж 4,506,406.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга жэмжээг санхүүжүүлэхээр 4,097,434.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 408,972.0 мянган төгрөгийг бусад орлогоор бүрдүүлж 4,720,906.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,097,434.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, бусад орлогоор 524,870.8 мянган төгрөг нийт 4,622,305.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 4,417,097.7 мянган төгрөгийг зарцуулж, 202,826.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,417,097.6 мянган төгрөг буюу 98.02 хувьтай байгаа нь нийт цалин, нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 17,493.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 19,279.4 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 2,425.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 455.8 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний зардлыг 561.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70805	Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг	4,506,406.2	2,576,788.1	83,602.7	98.0
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	4,364,385.3	4,296,769.2	67,616.1	98.5
1.2	80219	Хангамж бараа материалын зардал	38,399.7	35,974.0	2,425.7	93.7
1.3	80215	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	2,600.0	2,550.0	50.0	98.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд “Консерваторийн ерөнхий боловсролын сургуулийн барилга, Циркийн сургуулийн заалны барилга, Боловсролын үнэлгээ, мэдээллийн төвийн барилга, Консерваторид нэн шаардлагатай мэрэгжлийн хөгжмийн зэмсэг, техник хэрэгслээр хангах гэсэн 4 төсөл арга хэмжээг 2021-2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хамтран хэрэгжүүлэх” зорилгоор хамтран ажиллах гэрээг БШУЯ-тай байгуулсан боловч “Сургуулийн газрыг хамгаалах түр хороо”-ны шаардлагаар 2021 оны 05 дугаар сарын 12- ны өдөр гэрээ цуцлагдсан байна.

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, арга хэмжээнд дараах онцлох асуудлуудыг байна. Үүнд:

- Ковид-19 цар тахлын улмаас 2020-2021 оны хичээлийн жилд Консерваторийн Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт /танхимын ба цахим хичээл/ асуудал шийдэл” сэдэвт эрдэм шинжилгээний хуолын 2 дугаар үе шатыг 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулахад нийт 603.9 мянган төгрөгийг зарцуулсан;
- Польшийн суут хөгжмийн зохиолч Ф.Шопены нэрэмжит олон улсын төгөлдөр хуурчдын уралдааныг 2021 оны 11 дүгээр сарын 18-20-ны хооронд гурав дахь зохион байгуулж Польшийн ЭСЯ-наас 11,364.5 мянган төгрөгийг санхүүжүүлж зарцуулсан;
- Монгол Улсын консерватори Швейцарын Хөгжлийн Агентлагийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан “World Music Online Competition for young artists-2021” уралдааны зохион байгуулж Швейцарын Хөгжлийн Агентлаг санхүүжүүлсэн;
- БШУЯ Монгол Улсын консерваторийн үлээвэр хөгжмийн тэнхэмд 270.0 сая төгрөгийн үнэ бүхий “Ямаха” брэндийн 26 төрлийн хөгжмийн зэмсэгүүдийг хүлээлгэн өгсөн;

3.8 Аудитын гол асуудал

Монгол Улсын консерватори нь төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан төсвийг тушаал хавсарган орон тооны бус гэрээт хуулийн зөвлөх албан бичиг, тушаал, боловсруулсан бичиг бааримт дээр хяналт хэрэгжүүлэхгүй, “Журам шинэчлэн батлах тухай” 2017оны 346 дугаар тогтоолоор (ЗГ-ын 2019-1-9 ний өдрийн 5 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон) багш ажилчдын үр дүнгийн шагнал олгосон, төсвийн хөрөнгийг зарцуулахад тавих хяналт сул байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

Цалингийн зардал, батлагдсан төсөв, орон тоо хэтрүүлээгүй боловч тайлант оны эцэст гэрээт ажилчин, цагийн багш 112, тэтгэвэрт гарсан 94, үүнээс 65 аас дээш настай 34 багш нийт 337 хүнд цалин тооцон олгож байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан оруулбал зохих мэдээлүүдийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Монгол улсын консерватори нь нийт 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас бүтэн жилээр байршуулах мэдээлэл санхүүгийн тайланг хугацаа хоцроон байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, зөвлөмж өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 17,729.2 мянган төгрөгийн алдаа 5 зөрчил илэрүүлснээс 6,529.2 мянган төгрөгийн зөрчлийг залруулах, 11,200.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч жилийн эцсийн аудитаар дахин хянахад 6,529.2 мянган төгрөгийн алдаа зөрчийг залруулаагүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 33,593.1 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн биелэлт 80.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	33,593.1	2	33,593.1	1	-	80.0
Нийт дүн	3	33,593.1	2	33,593.1	1	-	80.0

Нягтлан бодох бүртгэл хөтөлт, санхүүгийн тайлагналыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн аккруэл сууриар бүртгэж тайлагнах зөвлөмжийг хэрэгжүүлж, Худалдан авалтын гэрээнд анхан шатны дэмжих баримтгүй 32,547.1 мянган төгрөг, төлбөрийн цахим баримтгүй хэрэгжүүлэх талаар өгсөн зөвлөмжийн зөрчлийг 20,403.2 мянган төгрөгөөр давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, хөгжмийн зэмсэг, үндсэн хөрөнгийн биет тооллого хийх, орон тоо, цалин хөлсний тушаал шийдвэр, цалингийн тооцооллыг дахин авч үзэх, хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ гэх мэт төсвийн хөрөнгө, цалингийн санг хэмнэж ажиллаж байгаа эсэхийг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 86,825.6 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрүүлснээс, 520.0 мянган төгрөгийн зөрчилд акт, 42,178.6 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 44,127.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 9 алдаа, зөрчлийн дүн 81,759.2 төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 35,382.9 мянган төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдааны залруулга хийгдээгүй.

4.2 Төлбөрийн акт

Үндсэн цалингийн албан тушаалын зэрэглэлийг буруу тогтоож сургалт бодлого бодлого зохицуулалтын мэргэжилтэн 2 ажилтанд анги даалгаж 520.0 мянган төгрөгийн цалинг илүү олгосон нь сургалтын албаны үндсэн чиг үүргийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг буруутай этгээдээр төлүүлэх, Төлбөрийн акт тогтоох,

4.3 Албан шаардлага

1. Коронавирус халдвар /КОВИД-19/ цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээд гамшгаас хамгаалах бүх нийтийн зэрэгт шилжүүлж хөл хорио тогтоосон хугацаанд ажилчдад унаа, хоолны хөнгөлөлт 2,460.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь ЗГ-ын тогтоол 2021 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 91, 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 104-р тогтоол "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай", Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан төсвийн хөрөнгийг үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан "төсвийн хөрөнгийг үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, Албан шаардлага өгөх.

2. Төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажил албан тушаалаас чөлөөлөн, Сүхбаатар дүүргийн Иргэний анхан шатны шүүхийн 2021 оны 01-р сарын 26 -ны өдрийн 181/ШШ2021/00194 дүгээр шийдвэрээр урьд ажиллаж байсан албан тушаалд нь эргүүлэн томилон ажилгүй байх хугацааны 11200,0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хууль, Хохирол барагдуулах, 103.1."Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", Иргэний хуулийн 498.5."Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй" Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйл.Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих, 50.1."Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ" гэснийг мөрдөн ажиллаагүй, нягтлан бодох бүртгэлийн эрх ба үүрэг, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Захиргааны ерөнхий хууль, Иргэний хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан “төсвийн хөрөнгийг үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, Албан шаардлага өгөх.

3. Төлбөр тооцоог цаг тухай бүр хянаж баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгө, бараа материалын орлогыг тухай бүр хянаагүй анхан шатны баримтын бүрдэл дутуу 23 408,2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан байна.

Энэ нь Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг: 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил гүйлгээ бүртгэхгүй байх, Албан шаардлага өгөх.

4. Нийгмийн даатгалын тайлангаар тайлагнасан цалин, тооцоолсон нийт цалингийн зардлын дүн 5,066.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-ыг мөрдөн ажиллах, цалин хөлсний тооцооллыг үнэн зөв хийх, Албан шаардлага өгөх.

5. Батлагдсан удардах ажилтан 3, Цалингийн зардлын төсвийг хэтрүүлээгүй ч гүйцэтгэлээр 12 удирдах ажилтан томилогдон, Сургалт эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, Эрдэм шинжилгээ инновацын албаны дарга, Эрдэм шинжилгээ инновацын албаны зөвлөх ...г.м орон тоогоор ажиллаж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан “төсвийн хөрөнгийг үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх, толилуулга ба тодруулга гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээд шатны төсвийн захирагчийн батласан орон тоог мөрдөн ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, Албан шаардлага өгөх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийтийн тээврийн унааны хөнгөлөлтийн Ахмад настан тэтгэвэрт гарсан ажилтан албан хаагчдад олговор 44.0 мянган төгрөгийг тооцоолон олгосон байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам", Ахмад настны тухай хуулийн 8.1.5, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай

хуулийн 32.8-д заасны дагуу ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл (таксинаас бусад)-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчих гэснийг дагаж мөрдөж, төсвийн хөрөнгийг хэмнэж ажиллах,

2. Үр дүнгийн шагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

“Журам шинэчлэн батлах тухай” 2017оны 346 дугаар тогтоолоор (ЗГ-ын 2019-1-9 ний өдрийн 5 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон) багш ажилчдын үр дүнгийн шагналд тайлант онд нийт 44,127.0 мянган төгрөг олгосон байна.

Өгсөн зөвлөмж:

ЗГ-ын 2019 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”ын 4.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал гэснийг дагаж мөрдөж, цалингийн санг хэмнэж ажиллах,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Монгол Улсын консерваторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5. 5. 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

мянган.төгрөг

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
							Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:																
1	Монгол Улсын консерватори	АХГ-2022/45/НА-СТА-ТШЗ	Нийтийн тээврийн унааны хөнгөлөлтийн Ахмад настан тэтгэвэрт гарсан ажилтан албан хаагчдад олговор 44.0 мянган төгрөгийг олгосон	Завсрын аудитаар залруулах зөвлөмж өгсөн залруулаагүй тул Албан шаардлага хүргүүлэх	1	44.0									1	44.0
2	Монгол Улсын консерватори	АХГ-2022/45/НА-СТА-ТШЗ	Коронавирус халдвар /КОВИД-19/ цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, нийтийн зэрэгт шилжүүлж хөл хорио тогтоосон хугацаанд ажилчдад унаа, хоолны хөнгөлөлт 2460,0 мянган төгрөг олгосон	Завсрын аудитаар залруулах зөвлөмж өгсөн залруулаагүй тул Албан шаардлага хүргүүлэх	1	2,460.0					1	2,460.0				
3	Монгол Улсын консерватори	АХГ-2022/45/НА-СТА-ТШЗ	Төрийн албан хаагчийг үндэслэлгүй	Албан шаардлага хүргүүлэх	1	11,200.0					1	11,200.0				

Монгол Улсын консерваторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			ажлаасчөлөөлж шүүхийн шийдвэрээр албан тушаалд эргүүлэн томилон ажилгүй байх хугацааны цалин 11,200:0 мянган төгрөг олгосон													
4	Монгол Улсын консерватори	АХГ-2022/45/НА-СТА-ТШЗ	Өмнөх аудитаар илэрсэн алдаа зөрчлийг дахин гаргаж тайлант онд 16 ААН, харилцагчаас 23,408.2 мянган төгрөгийн худалдан авалтын цахим И баримт гаргуулан аваагүй	Албан шаардлага хүргүүлэх	1	23,408.2					1	23,408.2				
5	Монгол Улсын консерватори	АХГ-2022/45/НА-СТА-ТШЗ	Батлагдсан удардах ажилтан 3, Цалингийн зардлын төсвийг хэтрүүлээгүй ч гүйцэтгэлээр батлагдсан орон тоог хэтрүүлэн томилгоо хийн удирдах ажилтан 12 томилогдон ажиллаж байна	Албан шаардлага хүргүүлэх	1	-					1	-				
6	Монгол Улсын консерватори	АХГ-2022/45/НА-СТА-ТШЗ	Нийгмийн даатгалын тайлангаар тайлагнасан цалин, тооцоолсон нийт цалингийн зардлын дүн 5,066.4 мянган төгрөгөөр зөрүүтэй	Албан шаардлага хүргүүлэх	1	5,066.4					1	5,066.4				
7	Монгол Улсын консерватори	АХГ-2022/45/НА-СТА-ТШЗ	ЗГ-ын 2019-1-9 ний өдрийн 5 дугаар тогтоолоор хүчингүй	Зөвлөмж өгөх	1	44,127.0									1	44,127.0

Монгол Улсын консерваторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			болсон 2017-346 р тогтоолоор үр дүнгийн шагнал р улиралд олгосон													
8	Монгол Улсын консерватори	АХГ-2022/45/НА-СТА-ТШЗ	Сургалт бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн Б.Нандин-Эрдэнэ, О.Энхтүвшин нарт анги удирдуулж 520.0 мянган төгрөгийн цалин олгосон.	Акт тогтоох	1	520.0			1	520.0						
Дүн					8	86,825.6	-	-	1	520.0	5	42,134.6	-	-	2	44,171.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
9	Монгол Улсын консерватори	АХГ-2022/45/НА-СТА-ТШЗ	нийт 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас бүтэн жилээр байршуулах 1 мэдээлэл санхүүгийн тайланг хугацаа хоцроон байршуулсан	Зөвлөмж өгөх	1	-									1	-
Дүн						-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн					9	86,825.6	-	-	1	520.0	5	42,134.6	-	-	3	44,171.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 28 /А0150058
АХГ-2022/45/НБ-СГБ-ТХН
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Улсын Консерваторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь Сургалт, бодлого зохицуулалтын газрын мэргэжилтнүүдээр анги удирдуулж, цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.2. "төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", 16.5.5. "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2. "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үндэслэлгүй олгосон цалин болох 520,000.00 /таван зуун хорин мянга/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкн дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Консерваторийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Пүрэвхүү, ерөнхий нягтлан бодогч Д.Болормаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ж.ОЮУНБИЛЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 184/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/45/НА-СТА-ТШ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Улсын Консерваторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажил албан тушаалаас чөлөөлж Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 181/ШШ2021/00194 дүгээр шийдвэрээр тухай албан тушаалд нь эргүүлэн томилон, ажилгүй байх хугацааны 11,200,000.00 төгрөг олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хууль 103.1. "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5. "гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", Төсвийн тухай хууль 6.4.1. "төсвийн хөрөнгийг үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Захиргааны ерөнхий хууль, Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Консерваторийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Пүрэвхүү, ерөнхий нягтлан бодогч Д.Болормаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ж.ОЮУНБИЛЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-180.Docx

0010800539



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 186/АХГ-2022/45/НА-СТА-ТХН

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Улсын Консерваторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг дахин давтан гаргаж, тайлант онд 16 ААН харилцагчаас 23,408,200.00 төгрөгийн худалдан авалтын дахин давтагдашгүй дугаартай төлбөрийн цахим И баримт аваагүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.2. Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, ... мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг: 20.1.4. Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Татварын ерөнхий хууль. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Консерваторийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Пүрэвхүү, ерөнхий нягтлан бодогч Д.Болормаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
 ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
 ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
 Б.СЭРЖМЯДАГ
 Ж.ОЮУНБИЛЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264211

\\0.10.10.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-181.Docx

0010800593



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 185/А0150058

АХГ-2022/45/НА-СТА-ТХМ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Улсын Консерваторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан удирдах ажилтан 3, Цалингийн зардлын төсвийг хэтрүүлээгүй ч гүйцэтгэлээр батлагдсан орон тоог хэтрүүлэн томилгоо хийн удирдах ажилтан 12 томилогдон Сургалт эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, Эрдэм шинжилгээ инновацын албаны дарга, Эрдэм шинжилгээ инновацын албаны зөвлөх ...г.м орон тоогоор ажиллаж байна.

Энэ нь Дээд шатны төсвийн захирагчийн баталсан орон тоо, Төсвийн тухай хуулийн 6.4.1. "төсвийн хөрөнгийг үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах", гэж заасантай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээд шатны төсвийн захирагчийн баталсан орон тоо, Төсвийн тухай хууль, бусад тогтоомжийг хэрэгжүүлж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Консерваторийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Пүрэвхүү, ерөнхий нягтлан бодогч Д.Болормаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ж.ОЮУНБИЛЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264211

\\10.10.10.20\Bichig_Kherag\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-183.Docx

0010800596



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 141/А0150058
АХГ-2022/45/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Улсын Консерваторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж хөл хорио тогтоосон хугацаанд ажилчдад унаа, хоолны хөнгөлөлт 2,640,000.00 төгрөг олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 91, 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 104 дүгээр тогтоол "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай", Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль,

Төсвийн тухай хуулийн 6.4.1. "төсвийн хөрөнгийг үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Консерваторийн захиралын үүрэг гүйцэтгэгч Ц.Пүрэвхүү, цалингийн тооцооны нягтлан бодогч Д.Бүжинлхам нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ж.ОЮУНБИЛЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-2642311

9006109

9019120

\\00.10.10.20\Bichig_Kherge\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gaar-159.Docx

0010800509



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 184/А0150058
АХГ-2022/45/МН-СТБ-ТХН

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Улсын Консерваторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын тайлангаар тайлагнасан цалин, тооцоолсон нийт цалингийн зардлын дүн 5,066,400.00 төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хууль 16 дугаар зүйл. Нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1. "... санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах, 14 дүгээр зүйлийн 14.3.2. журналд бичих; 14.3.3. дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх; 14.3.4. ажил, гүйлгээний мэдээ гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгалын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Консерваторийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Пүрэвхүү, цалингийн тооцооны нягтлан бодогч Д.Бүжинлхам нарт хариуцуулав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККУРАЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ж.ОЮУНБИЛЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Вэсгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-184.Docx

0010800539

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing the summary.